



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 05 сарын 11 өдөр

Дугаар А/267


Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1/а/, 29.2, Сангийн сайдын 239 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Уурхайчин соёлын ордны морин хуурын дугуйлангийн сурагч О.Батнасан нь “Морин төвөргөөн” уран бүтээлийн тайлан тоглолт хийж байгаатай холбогдуулан дэмжлэг үзүүлсүгэй.

2. Уг зардалд шаардагдах 400000 /Дөрвөн зуун мянган/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.



ЗАСАГ ДАРГА

Д.БАТЛУТ